



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/803

Улаанбаатар хот

### "Тэнгэр" олон улсын наадам зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 25/06 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/803 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 155 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм"-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын уламжлалт соёлын өв болох тэнгэр, газар шүтлэгийн зан заншлыг тусгай сонирхлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлж, нийслэл Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах зорилгоор "Тэнгэр" олон улсын наадмыг "Чингис Хааны Хүрээ" аялал жуулчлалын цогцолборт 2026 оны 06 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Наадмыг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. "Тэнгэр" олон улсын наадмыг зохион байгуулахад шаардагдах төсвийг холбогдох зардлаас хууль, журмын дагуу гаргахыг Ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

4. Наадмыг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

